МЭДЭЭ · 2020 оны 1-р сарын 24

"ПРОКУРОР ТӨР, НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ НЬ" СЭДЭВТ ИЛТГЭЛИЙН УРАЛДААН ЗАРЛАЖ БАЙНА



Прокурорын байгууллагын 90 жилийн ойд зориулсан “ПРОКУРОР ТӨР, НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ НЬ” сэдэвт илтгэлийн уралдааныг хууль зүйн их дээд сургуулийн оюутнуудын дунд зарлаж байна.

Зорилго: Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ажилд оруулах прокурорын хувь нэмэр, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, улмаар уг ажлыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход оршино.

Оролцогч: Хууль зүйн их дээд сургуулийн оюутнууд.

Илтгэл ирүүлэхэд тавигдах шаардлага:

- Цаасны хэмжээ А4;
- Үсгийн фонд Arial;
- Үсгийн хэмжээ 12;
- Мөр хоорондын зай 1.5;
- Дээд 1.5 см, Доод 2 см, Зүүн 3 см, Баруун 1.5 см;
- Хуудасны тоо /нүүр хуудас, хавсралт оролцуулалгүй/ 4-10;
- Нүүр хуудсанд сургуулийн нэр, курс, овог, нэр, холбоо барих утасны дугаар;
- Илтгэлийг “Улсын Ерөнхий Прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах алба”-нд гэж хаяглан **gpo@prokuror.mn** цахим хаягаар, эсхүл Улсын Ерөнхий прокурорын газар Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу, Хуульчдын гудамж 15/1, 1 давхарт 111 тоот өрөөнд файл хэлбэрээр ирүүлнэ.

Агуулга: Прокурор төр, нийтэд учирсан хохирлыг иргэний журмаар нэхэмжлэх эрх, хууль зүйн зохицуулалт, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ажилд оруулах прокурорын хувь нэмэр, хэрэгцээ, шаардлага, уг ажлыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцдог дэлхийн улс орнуудын эрх зүйн зохицуулалт, манайд хэрэгжүүлж болох сайн туршлага, цаашид энэ талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгоход шинэлэг санаа дэвшүүлсэн байх.

Хүлээн авах хугацаа: Илтгэлийг 2020 оны 2 дугаар сарын 20-ноос 25-ны хооронд хүлээн авна.

Шалгаруулалт: Илтгэлийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан шалгаруулж, **www.prokuror.mn** цахим хуудсаар эхний 3 байр эзэлсэн оролцогчдын нэрсийг зарлана. Тэргүүн байр эзэлсэн оролцогч Прокурорын байгууллагаас зохион байгуулах онол, практикийн бага хуралд оролцож илтгэл тавина. Илтгэлийн уралдаанд идэвхитэй оролцож шалгарсан, судалгааг бүрэн дүүрэн хийсэн байх нь

цаашид прокурорын байгууллагад ажиллах хүсэл, эрмэлзэлтэй оролцогчид давуу тал болох боломжтой.

Шагнал:

Нэгдүгээр байр- Өргөмжлөл, 1.000.000 төгрөг;

Хоёрдугаар байр - Өргөмжлөл, 600.000 төгрөг;

Гуравдугаар байр – Өргөмжлөл, 300.000 төгрөг.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2981